



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/1354

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн Иргэд, олон нийтэд  
үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын эргэлтийн бус  
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.7 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 8 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 19,814,000.00 (арван есөн сая найман зуун арван дөрвөн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн Иргэд, олон нийтэд үйлчлэх төв ОНӨААТҮГ (Б.Амарзаяа)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 1 нэр төрлийн 1,650,000.00 (нэг сая зургаан зуун тавин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 7 нэр төрлийн 18,164,000.00 (арван найман сая нэг зуун жаран дөрвөн мянга) төгрөгийн хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Баянзүрх дүүргийн Иргэд, олон нийтэд үйлчлэх төв ОНӨААТҮГ (Б.Амарзаяа)-д, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюумаа* В.ОЮУМАА





Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн АЖЧ дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Багууллагын нэр: Баянзүрх дүүргийн иргэдийн Иргэд, олон нийтэд үйлчлэх төв ОНӨААТҮГ

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан гийж	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	НӨХГ-ын мэргэжил Т-ний дүгнэлт	ҮХХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Сандал МТ160	10	ш	2	251,750.00	503,500.00	503,500.00	-	эвдэрсэн	актлах	устгах	татах
2	Тумбочка АМЗВ	10	ш	1	123,500.00	123,500.00	123,500.00	-	эвдэрсэн	актлах	устгах	татах
3	Бичгийн самбар	10	ш	28	268,000.00	7,504,000.00	7,504,000.00	-	эвдэрсэн	актлах	устгах	татах
	<b>Тавилга эд хогшлын дүн</b>				<b>643,250.00</b>	<b>8,131,000.00</b>	<b>8,131,000.00</b>					
1	Санхүүгийн программ	5	ш	1	1,650,000.00	1,650,000.00	852,500.00	797,500.00	ашиглахгүй болсон	актлах	устгах	устгах
	<b>Биет бус хөрөнгийн дүн</b>				<b>1,650,000.00</b>	<b>1,650,000.00</b>	<b>852,500.00</b>	<b>797,500.00</b>				
1	Компьютерийн дэлгэц	5	ш	1	350,000.00	350,000.00	350,000.00	-	ашиглахгүй болсон	актлах	татах	татах
2	Процессор	5	ш	1	1,730,000.00	1,730,000.00	1,730,000.00	-	ашиглахгүй болсон	актлах	татах	татах
3	Принтер	5	ш	2	786,500.00	1,573,000.00	1,573,000.00	-	ашиглахгүй болсон	актлах	татах	татах
4	Принтер	5	ш	8	797,500.00	6,380,000.00	6,380,000.00	-	ашиглахгүй болсон	актлах	татах	татах
	<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>				<b>3,664,000.00</b>	<b>10,033,000.00</b>	<b>10,033,000.00</b>					
	<b>Нийт данснаас хасах хөрөнгийн дүн</b>					<b>19,814,000.00</b>	<b>19,016,500.00</b>					
	Үүнээс Худалдах хөрөнгө					-						
	Актлах хөрөнгө					<b>1,650,000.00</b>						
	Татан төвлөрүүлэх хөрөнгө					<b>18,164,000.00</b>						
	Худалдсанаас олох орлого					-						
	НӨХГ-т төвлөрүүлэх 30%					-						